

Монгол Улсын Их Сургуулийн Монгол Судлалын Төв
ACTA MONGOLICA
сэтгүүлийнхээ энэ дугаарыг нэрт монголч эрдэмтэн,
Валтер ХАЙССИГ профессорын
90 насны ойд зориулав.



**Валтер ХАЙССИГ (Walther HEISSIG) профессор
(2003 он)**

ОРШИЛ БИЧИХИЙН УЧИР...

МУИС-ийн Монгол Судлалын Төв (Centre for Mongol Studies)-өөс эрдэм шинжилгээний жил тутмын хэвлэл - АСТА MONGOLICA сэтгүүлийнхээ гутгаар ботийг бүхэл бүтэн амьдрал, эрдэм шинжилгээний үйл ажилаа монголын судлалд нэгэн үзүүрт сэтгэлээр эргэлтгүй зориулсан профессор В. Хайссиг (W. Heissig)-ийн эснэсэний 90 насны ойд зориулан толилуулж буй учир профессор Удо Баркманн(Udo Barkmann)-ы бэлтгэсэн В. Хайссиг авгайн намтар болон бүтээлийн жагсаалтыг тусхайлан оруулсан болно.

2003 онд АСТА MONGOLICA сэтгүүлийн хоёрдугаар дэвтэр гарсанаас хойш тус төвийн MONUMENTA MONGOLICA хэмээх дурасхалт бичигийг хэвлэн нийтлэдэг цувралын IV. 1 дэвтэрээр залуу эрдэмтэн Б. Баярсайханы бэлтгэсэн "Монгол цаазын бичиг"-ийн эх бичигийн судлагааг хэвлэн нийтлүүлсэнээс гадна үүнээс өмнө олон нийтийн хүртээл болж амжаагүй "Субашид" хэмээх сургаали-тайлбар зохиолын нэгэн монгол орчуулгыг хэвлэлд бэлэдхэж удалгүй гаргахаар завдаж байна. Мөн тус төвийн SERIES MONOGRAPHICA MONGOLICA хэмээх ганц сэдэвт бүтээлийн цувралын хоёрдугаар ботид Ц. Шагдарсүрэнгийн "Монголчуудын утга соёлын товчоон" номын нэмж зассан эрдэм шинжилгээний хоёрдугаар хэвлэлийг бэлэдхэсэн бөгөөд удахгүй олон уншигчийн гар дээр очно гэж найдаж байна.

Толилуулан буй энэ дугаарт монгол хэл, түүх, соёл, уран зохиол, эх бичигийн чиглэлээр дотоод гадаадын монгол эрдэмтэдийн туурвисан шинэ өгүүлэл, тэмдэглэлийг оруулахыг чармайсаны хажуугаар гадаадад хэвлэгдсэн боловч МУИС-ийн хичээлийн хөтөлбөрт шууд холбогдох зарим нэг өгүүлэлийг залуу судлагч, оюутан нарт зориулан дахин хэвлэсэн зүйл бас бий. Мөн урьд өмнө судлагааны хүрээнд ороогүй, шинэ тутам олдсон эх бичиг, сурвалжийн талаархи зарим судлагаа болон анхны мэдээг багтаасан болно.

2002 онд ХБНГУ-ын Эрдэмийн Солилцооны Алба буюу DAAD хэмээх байгуулгаас МУИС-ийн Монгол судлалын төвийн үйл ажиллагааг дэмжин бэлэглэсэн цахим тоног төхөөрөмжийн талаар үүнээс өмнө мэдээлж байсан билээ¹. 2003 онд Германы тал Монгол Судлалын Төвийн номын санг Asiatische Forschungen цуврал номын 100 гаруй ботиор баяжуулан өглөө.

¹ АСТА MONGOLICA, Volume 2 (208), Ulaanbaatar, p. 3.



Эдгээр тоног төхөөрөмж болон судлагааны цуврал бүтээлүүд нь бидний эрдэм шинжилгээ-сургалтын өдөр тутамын үйл ажиллагаа болон "Дэлхийн монгол судлалын сан" байгуулах зэрэг цаашидын судлагааны ажилд үлэмж тус болж байгааг тэмдэглэхийн сацуу Германы Эрдэмийн Солилцооны Алба буюу DAAD болон түүний Монгол дахи төлөөлөгч Удо Баркманн профессорт МУИС-ийн Монгол Судлалын Төвийн нэрийн өмнөөс гүн талархалаа дахин илэрхийлэе.

Саяхан 90 насны сүүдэр зэргэцсэн нэрт монголч эрдэмтэн В. Хайссиг профессорын өлмий бат байж, насан хутаг нь арвитах болтугай.

МУИС-ийн Монгол Судлалын Төвийн
Эрдэмтэн нарийн бичигийн дарга

У. Шагдарсүрэн

2003 оны 12-р сар.
Улаанбаатар хот.